



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ,УРЛАГИЙН
ГАЗАР**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 ОН

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Сайншанд сум

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлага болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, цаашид соёлын салбарын үйл ажиллагааг орон нутагт үр нөлөөтэй зохион байгуулахын тулд төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний ажлыг зохион байгуулав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн биелэлт гаргасан заалтын тоо, тайланд тавигдах шаардлагыг хангасан байдалд хяналт-шинжилгээ хийж, үнэлсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн биелэлтийн тайланд хариуцсан мэргэжилтнүүдээс тодруулга авах, бодит гүйцэтгэлийг нягтлан шалгах зэрэг аргуудыг хэрэглэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийлээ.

Тус бодлогын баримт бичгийн 6 бодлого 21 арга хэмжээний төлөвлөлтийн жилийн эцсийн биелэлтийг өссөн дүнгээр гаргаж нэгтгэн, зорилт арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

№	Зорилт	Үнэлгээ						Нийт заалт	Нийт дундаж
		100%	90%	70%	50%	30%	0%		
1	Засаглалын бодлого	4	2						96.6%
2	Хүний хөгжлийн бодлого	2							100%
3	Засаглалын бодлого	1							100%
4	Хүний хөгжлийн бодлого	8	2						98%
5	Засаглалын бодлого	1							100%
6	Орон нутаг, хөдөөгийн хөгжил	1							100%
	Нийт	17	4						98.1%

Дөрөв. Дүгнэлт

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 дугаар тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа – 2” /2020-2024/ үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулсан 2024 оны Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

“Үр дүнд суурилсан санхүүжилт”-ээр салбарын 17 байгууллагад үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 406,0 сая төгрөгийг олгож соёлын салбарын албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөлийг бий болгож сургалтын болон хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллалаа.

Соёлын салбарын албан хаагчид 2022-2024 онуудад мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтуудад бүгд хамрагдаж чадавхжсанаас гарсан үр дүн нь Соёлын яамнаас соёлын салбарын байгууллагуудад ажлын үзүүлэлтээр үр дүнд суурилсан санхүүжилтийг 2022 онд 153,0 сая төгрөг авсан нь 2023 онд 253,0 сая төгрөг болж өссөн нь салбарын ажлын үндсэн үзүүлэлтүүд өссөн дүнтэй байлаа.

СУГ-аас БШУГ-тай хамтран сар бүрийн сүүлийн өдрийг “Соёлын өдөр” болгон зарласнаар нийт соёлын байгууллагууд ЕБС,СӨБ хамтран угийн бичгийн сургалт, үндэсний өв уламжлал,уртын дуу, морин хуур,бий биелгээг сурталчлах,соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгууллаа.Соёл урлагийн газар,Саранхөхөө театр, МССТ, Өргөн сумын соёлын төв хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж хүүхдийн өрөөг тохижууллаа.Салбарын хэмжээнд хөгжим, бүжгийн дугуйланг 9 сум хичээллүүлж 479 хүүхэд хамрагдсан.Саранхөхөө театр, Замын-үүд, Өргөн сумдад хүүхэд хамгааллын бодлого,соёл спорт олон нийтийн арга хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах журмыг танилцуулж чиглэл өгч ажилласан. Саранхөхөө театр Э.Нямдуламын зохиол “Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд, Э.Нямдуламын зохиол “Чандмань Эрдэнэ” жүжгийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулан шинэ уран бүтээл туурвилаа.Энэхүү жүжгээр байгаль эх дэлхийгээ хайрлах, усны үнэ цэнийг мэдрэх, цаашлаад хүүхэд бүр байгальтайгаа зөв харьцах хайрлах үзэл бодлыг суулгахыг зорьсон. Аймгийн нийт соёлын байгууллагууд “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аянд нэгдэн соёлын үйл ажиллагаар дамжуулан соён гэгээрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгууллаа. Номын баяр -2024 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хүүхэд багачуудад зориулсан зураг зурах хөлөгт тоглоом тоглох ,ном унших үндэсний бичгээр бичих зэрэг соёлын олон үйл ажиллагаа задгай талбайд нээлттэй зохион байгуулж 650 гаруй иргэд,хүүхэд багачууд хамрагдлаа.Соёлын яамнаас зохион байгуулдаг соёлын эрхийн бичгийн хүрээнд хүүхдэд чиглэсэн 4 үйл ажиллагааны материалыг хүргүүлж хүүхдэд багачуудыг соёлын эрхийн бичгээр үйлчилгээ авах боломжийг ханган ажиллалаа.“Саран хөхөө театр”-ын хөгжим ангиас санаачилан, ЗДТГ, Соёл урлагийн газар хамтран“Авьяслаг хөгжимчид” үндэсний анхдугаар уралдааныг зохион байгуулж 7 сумын 140 хүүхэд багачууд хамрагдлаа.Уралдаанд оролцсон 3 хүүхдийг СУИС-д суралцах эрхийн бичгээр шагнасан.

Монгол улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан “Музейтэй Дорноговь” сарын аяны хүрээнд 10 жил тогтвортой хичээллэж буй “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлангийн болон өвлөн уламжлагчдын

тоглолтыг "Саран Хөхөө" театрт зохион байгууллаа. Уртын дууч Ч.Цэрэндэжид багшийн удирдлага дор урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй тус дугуйлангийн суралцагчдаас аймаг, улс, бүсийн чанартай уралдаануудад тогтмол амжилт үзүүлсээр ирсэн.

Өвлөн уламжлагчдаас Соёлын яамны "Тэргүүний ардын авьяастан" цол тэмдгээр шагнуулахаар 10 хүний материалыг хүргүүллээ.

Монгол гэрийн уламжлалт урлал биет бус өвийн зан үйлийг сурталчлах зорилгоор Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол-гэр" үзэсгэлэн арга хэмжээнд оролцож уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээлийг 9 хоногийн турш Улаанбаатар хотын төв талбайд сурталчлан алдаршууллаа. Тус арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Соёл урлагийн газраас хэрэгжүүлсэн "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт соёлын биет бус өвийн уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадам, уриа дуудлагын ай савын төрлүүд болох монгол шатрын тоглоом наадгай, шагайн харваа болон "Найрын дэг ёс" -ийг танилцуулан шатар болон шагайн холбоод, өвлөн уламжлагч нартай хамтран ажиллалаа.

Иххэт сумын соёл, спортын төвөөс үндэсний шагайн харвааны тэмцээн, морь бөхийн цол дуудах бүсийн уралдаан зэрэг соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэн сурталчлах 2 удаагийн арга хэмжээ, Хатанбулаг сумын соёл, спортын төвөөс өвлөн уламжлагч Д.Лувсанбалдангийн аман хууч яриагаар үлгэрийн контент бүтээлгэж алдаршуулах ажлуудыг зохион байгуулж олон нийтэд сурталчилж ажилласан.

Замын-Үүд сумын шагайн холбооноос санаачлан тус сумын ЗДТГ, Соёл, спортын ордон хамтран сумын 30 жилийн ойг угтан "Шагайн харваа-2024" тэмцээнийг аймгийн 6 сумдын 14 багийн 112 харваачдын дунд зохион байгуулж Н.Гантөмөр ахлагчтай баг тэргүүн байр эзэллээ.

Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.6, 4.1.3-т заасны дагуу Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэшсэн байдлын үнэлгээг 20%-аар нэмэгдүүлэх, зорилгоор СУИС-ын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран сумдын дуу хөгжмийн багш нарын ур чадварыг дээшлүүлж, чадавхжуулах 5 хоногийн сертификат олгох кредит тооцох сургалтад Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Өргөн, Хөвсгөл, Эрдэнэ зэрэг 8 сумын хөгжмийн багш нарыг, бүжиг заах арга зүй 40 цагийн 6 хоногийн сургалтад 9 бүжгийн багшийг хамруулан Улаанбаатар хотноо зохион байгууллаа. "Соёлын сэргэлт-2024" удирдах ажилтны зөвлөгөөн болон "Бүсчилсэн хөгжлийн бодлого" хэлэлцүүлэгт 14 сумын соёлын төвийн дарга, СУГ-ын удирдах ажилтан 3 албан хаагчийг хамрууллаа. Музейн үзүүлэлт дэглэлт арга зүйн сургалтад 14 соёлын төвийн дарга 14 музейн ажилтан хамрагдлаа. "Саран Хөхөө" театрт нэн шаардлагатай хөгжимчин мэргэжлээр СУИС-д 2023-2024 оны хичээлийн жилд 4 оюутныг 3 талт гэрээгээр аймгийн зардлаар захиалгаар сурган сургалтын төлбөрт 28,0 сая төгрөгийг шийдвэрлэлээ. 2000-2024 оны хичээлийн жилд ЕБС-иудад дуу хөгжмийн багш мэргэжлээр бэлтгэгдэж байгаа оюутнуудын төлбөрийг үргэлжлүүлэн аймгаас санхүүжүүлээ.

Тав. Үнэлгээ

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн 6 бодлогын 21 арга хэмжээг хэрэгжүүлж,

- Үр дүнтэй - 17
- Тодорхой үр дүнд хүрсэн – 4 арга хэмжээ байна гэж дүгнэн биелэлтийн дунджийг “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 98,1% гэж үнэллээ.

Зургаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангийн 21 арга хэмжээг тус байгууллага нь 2024 оны эхний хагас жилд хэрэгжүүлж “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн хэдий ч хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд хүргэж байна. Үүнд:

- ✓ Хэрэгжилтийг тайлагнахдаа МУЗГ-н 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын А/675 дугаар захирамжаар тус тус батлагдсан журмын дагуу заасан хугацаанд, үр дүнд суурилсан тайланг бодит тоон мэдээлэлд тулгуурлан бичих
- ✓ Тайланг бичихдээ тайланд тавигдах стандартыг бүрэн хангах /Оршил хэсэг, Үндсэн хэсэг, Дүгнэлт хэсэгтэй байх/
- ✓ Зөвхөн байгууллагын хэмжээнд бус салбарын хэмжээнд хийгдсэн ажлуудыг нэгтгэж тайлагнах
- ✓ Хийгдсэн ажлуудыг орхигдуулалгүй бүрэн гүйцэд, нуршилгүй, товч тодорхой тайлагнах хэрэгтэй.

ТАНИЛЦСАН:
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА



У.ГАНБААТАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК
МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.НАРАНЖАРГАЛ